*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН НЯМСҮРЭНГИЙН БАТНЯМ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. *Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга) болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Тайланд хугацаанд ГБХНХЯ болон НДЕГ-аас Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжүүлэхтэй холбоотой ирүүлсэн журам, заавар чиглэлтэй тухай бүр танилцан ажлын байран дээр мөрдлөг болгон ажиллаж байна. | 2025.04.23-2025.06.15 | |
| 2 | Арга хэмжээ 1.2. Ажил олгогч, иргэд, даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | Тухай бүр | - | 100% | Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчид бид төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэж үйлчлүүлэгчийн байр сууринаас тэдэнтэй харилцаж сайхан сэтгэгдэл үлдээж “Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх” эрхэм зорилгодоо хүрэхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлэн | 2025.04.23-2025.06.15 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллах ёстой. Энэ үүргийнхээ хүрээнд албан хаагчдадаа өдөр тутам ажлын байранд ажиллахдаа ёс зүйтэй, харилцаа хандлагадаа анхаарах, иргэдийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж ажиллах талаар шаардлагатай зөвлөмж чиглэлүүдийг өгч ажиллаж байна. Нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагч, ажил олгогч байгууллагуудад холбогдох мэдээ мэдээллийг хууль тогтоомжид зааснаар түргэн шуурхай хүргэх, чиглүүлэх, зөвлөгөө өгөх, хяналт тавих чиг үүрэг бүхий "ХӨТӨЧ БАЙЦААГЧ"-г 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулж байна.<br><br>Ингэснээр тус газраас үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагчид аль цонхноос ямар үйлчилгээ авахаас эхлээд шаардлагатай баримт бичгийн жагсаалт, өргөдөл, санал хүсэлт гээд олон асуудлыг нэг доор шийдвэрлүүлэх боломжтой юм. Мөн сэтгэл ханамжтай үйлчлүүлсэн иргэдээс талархал бичиж үлдээх болсон нь хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн юм.<br>Газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын дагуу нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулсан. Нийт 9 асуулт бүхий судалгааг авч үр дүнг тооцон тайланг НДЕГ-ын Үйлчилгээ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газарт хүргүүлсэн.<br><br>Тус судалгаанд 600 орчим иргэн хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан иргэдийн үйлчилгээний сэтгэл ханамж дараах байдлаар үнэлэгдсэн байна.<br><br>Хангалттай-82,1% буюу 4 оноо<br>Ойлгомжгүй-10,7% буюу 2 оноо<br>Хангалтгүй – 7,1% буюу 1 оноотой дүгнэгдсэн байна. | | |
| **Зорилт 2. "*Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт.*"** | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ 2.1. Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих; | 1 | - | 100% | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан цахим хуудсанд байршуулах нээлттэй мэдээллийн жагсаалт бүхий өөрт холбогдолтой заалтын дагуу мэдээллүүдийг бүрэн байршуулж ажилласан. | 2025.04.23-2025.06.15 | |
| **Гурав. "*Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*"** | | | | | | | |
| 4 | Арга хэмжээ 3.1. Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | Тухай бүр | - | 100% | Сургалт сурталчилгааны чиглэлээр Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, мэдээг дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд хүргүүлэн ажилласан. | 2025.04.23-2025.06.15 | |
| 5 | Арга хэмжээ 3.2. Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн | Тухай бүр | - | 100% | Эхний хагас жилийн байдлаар ажил олгогч байгууллагуудаас Нийгмийн даатгалын багц хуулийн талаар | 2025.04.23-2025.06.15 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | | | | сургалт авах хүсэлтэй нийт 9 албан бичиг ирснээс 5 байгууллагад сургалт зохион байгуулж, 4 байгууллагад зохион байгуулах өдөр хугацааг товлосон байна. | | |
| 6 | Арга хэмжээ 3.3. Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | Сургалт зохион байгуулсан тоо, хамрагдсан ажилтнуудын тоо | 10 удаагийн сургалтад давхардсан тоогоор 620 албан хаагч хамруулсан | 100% | Байцаагч ажилтнуудын мэргэжил мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тайлант хугацаанд танхимын 8 сургалтыг дотооддоо зохион байгуулан ажилласан.<br><br>Үүнд:<br>1. Үндэсний бичиг<br>2. Ажлын байран дахь стресс, түүнийг даван туулах арга зам<br>3. Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага<br>4. Нурууны суулт түүнээс урьдчилан сэргийлэх<br>5. AI /Хиймэл оюун ухаан/ хэрхэн ашиглах, албан хэрэгцээнд хослуулан ашиглах<br>6. SICOS программын шинэчлэл, түүний хэрэглээ<br>7. Авилга, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх<br>8. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам сэдвүүдээр тус тус танхимын сургалт зохион байгуулан нийт албан хаагчдыг хамруулан ажиллалаа. | 2025.04.23-2025.06.15 | |
| 7 | Арга хэмжээ 3.4. Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн | Сургалт зохион байгуулсан тоо, | 9 удаагийн сургалтад 9 аж ахуйн | 100% | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дэвшүүлсэн “Даатгуулагчдыг дэмжих, Нийгмийн даатгалын | 2025.04.23-2025.06.15 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | хамрагдсан ажилтнуудын тоо | нэгжийн 700 гаруй иргэд даатгуулагч, ажил олгогч хамруулсан. | | шимтгэлийн өрийг барагдуулах” зорилтын хүрээнд нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, түүний дотроос иргэд, даатгуулагчдын хамгийн их сонирхсон тэтгэврийн хуулийн шинэчлэл, одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийг сурталчилж, дараах ажлуудыг зохион байгууллаа.<br><br>Үүнд:<br><br>**1.** Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн төвтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, дэмжих, хамтран ажиллах” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 23–ны өдөр зохион байгуулан ажилласан. Тус өдөрлөгт 500 орчим иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>**2.** 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Баянгол дүүргээс “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аян-2025" өдөрлөгийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд тус газраас "Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай" сэдвээр илтгэл тавьж, хууль тогтоомжийг сурталчлан, мэдээлэл хүргэж оролцсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр “Нийгмийн хамгаалал” сэдвийн хүрээнд зохион байгуулсан сургалтад тус газраас Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, тэгш хүртээмжтэй нийгмийн даатгалын үйлчилгээг хүнд сурталгүй хурдан шуурхай хүргэх, Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжуудыг сурталчлах зорилгоор дүүргийн Хүүхэд, гэр бүл, хамгааллын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, 34 хороодын Засаг дарга, ажлын алба, хорооны нийгмийн ажилтан нарт мэдээлэл хүргэн, асуусан асуултад хариулт өгч, санал солилцон хамтран ажилласан.<br>4. Монгол улсын Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дахин магадлалыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 09/19 дугаар удирдамжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 18-27-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд дахин магадлал хийгдсэн. Тус ажлын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд гарсан дүгнэлт, зөвлөмжийг Эрүүл мэндийн төвийн эмч, удирдлагуудад танилцуулж цаашид авах арга хэмжээний талаар зөвшилцөн, сургалт зохион байгуулсан.<br>**5.** Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжуудыг сурталчлах зорилгоор "Хүннү мебель", "Мандах их сургууль", "ОСНААУГ ХҮТ-9", "ОСНААУГ Хэрэглэгчдэд үйлчлэх төв" зэрэг байгууллагуудад сургалт зохион байгуулан ажилласан. | | |
| 8 | Арга хэмжээ 3.5. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах; | Сурталчилсан тоо | - | 100% | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлтүүдийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчлах олон олон ажлыг зохион байгуулсан.<br>1. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, шинэчлэл, үзүүлж буй үйлчилгээ, газрын үйл ажиллагаа, цаг үеийн холбогдолтой 36 постер, 8 видео контент, мэдээ, мэдээллийг газрын албан ёсны фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан хүргэсэн.<br>2. Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 10, Авлигатай тэмцэх газрын 2, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 85 болон бусад газраас нийгмийн даатгалын хууль тогтоомжтой холбоотой ирүүлсэн мэдээ, мэдээллийг | 2025.04.23-2025.06.15 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай бүрд нь газрын пэйж хуудас болон байцаагч, ажилтнуудын фейсбүүкээр дамжуулан олон нийтэд түгээн сурталчлан ажилласан.<br>3. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлын хүрээнд МҮОНР телевизээр 2 удаагийн мэдээ бэлтгэн 3 удаагийн давтамжтай, UBS телевизээр мөн 2 удаагийн мэдээ бэлтгэн 3 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлан ажиллаж байна. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар /арга хэмжээ/-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үүрэг даалгавар (**Арга хэмжээ №1**) Ажлын бүтээмжийг дээшлүүлж нийтийг хамарсан ажилд бүрэн, идэвхтэй оролцоно. | Нийтийг хамарсан ажилд бүрэн, идэвхтэй оролцох | - | 100% | 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдөр Сонгино-Хайрхан дүүргийн НДГазраас зохион байгуулсан “И-Спорт”-н тэмцээнд оролцож гутгаар байр эзэлсэн. 2025 оны 04 дүгээр сард Бүх нийтээр “Мод тарих өдөр” 57 дугаар цэцэрлэгийн хашаанд ногоон төгөлд мод тарьсан. | 2025.04.23-2025.06.15 | |

**<u>Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт</u>**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Хиймэл оюун ухаанд суурилсан хэрэглээний сургалтад хамрагдах | Хэрэгжилтийн хувь | - | 100% | “ДИЖИТАЛ ШИЙДЭЛ БА ХИЙМЭЛ ОЮУНЫ ХӨГЖЛИЙН ТӨВ”-өөс зохион байгуулсан хиймэл оюун ухааны үндсэн ойлголтыг танилцуулах, албан хэрэгцээнд хиймэл оюун ухааныг ашиглан ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад ойлгомжтой хурдан шуурхай хүргэж түгээн дэлгэрүүлэхэд “AI” хиймэл оюун ухааныг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар мэдлэг олгох, ур чадварыг дээшлүүлэх лекц, хэлэлцүүлэг, харьцуулалт хийх семинарын ажил гэсэн нийт 5 цагийн багц сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байна. | 2025.01.02-2025.06.15 | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Монгол бичгийн сургалтад хамрагдах | Хэрэгжилтийн хувь | Анхан шатны сертификат | 40 | Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “......төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэрэгээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна” гэж заасны дагуу албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулж байна. | 2025.01.02-2025.06.15 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН | Н.БАТНЯМ / ......................... / | ......... ......... ......... |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |